


Компани нь хяналтын тогтолцоог Комплайнсын үйл ажиллагааны хөтөлбөр, Ёс зүйн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны журмын дагуу дараах бүтцээр хэрэгжүүлдэг.

Компанийн хяналтын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт:



Хяналтын чиг үүрэг:

Төлөөлөн удирдах зөвлөл түүний дэргэдэх аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлан гаргах үйл ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд болон компанийн эрсдлийн удирдлагын үйл ажиллагаанд давхар хяналтыг хэрэгжүүлж үр дүнг төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах, зөвлөмж гарган ажиллана. Дотоод хяналтын мэргэжилтэн нь Аудитын хорооны удирдамжийн дагуу үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн эрсдлийг тодорхойлох хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх захирал болон аудитын хороонд үр дүнг тайлагнана.

Комплайнсын мэргэжилтэн нь компанийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмуудад нийцэж байгааг үнэлэх, хяналт тавих, эрх зүйн сайжруулалт хийх, холбогдох чиглэлээр удирдлага болон мэргэжилтнүүдийг мэдээллээр хангана. Ажлын үр дүнг аудитын хороо болон гүйцэтгэх удирдлагад тайлагнана.